



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 4/543

Номгон

Г Гамшгаас хамгаалах дадлага, сургууль Г
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12/54 тогтоолын хавсралтаар батлагдсан 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.7, аймгийн Засаг даргын 2023 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/97 дугаар захирамж, аймгийн Засаг даргын 2023 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:



1.Баянхонгор аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.7 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах “Иж бүрэн сургууль”-ийг Баянбулаг, “Команд штаб”-ын сургуулийг Бөмбөгөр сумдад, аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах “Бэлэн байдлын үзлэг”-ийг Гурванбулаг сумдад тус тус зохион байгуулсугай.

2.Гамшгаас хамгаалах дадлага, сургууль, аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, хуваарийг хоёрдугаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

642311404

3.Гамшгаас хамгаалах дадлага, сургууль аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт шаардагдах **2,283,600** (Хоёр сая хоёр зуун наян гурван мянга зургаан зуун) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (хурандаа Ж.Алтангэрэл)-т даалгасугай.

ДАРГА  

Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 023 оны 10 дугаар
сарын 11-ний өдрийн 155 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	1. Б.Мягмарсүрэн	Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа;
Гишүүд	2. М.Төмөрчөдөр	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч;
	3. Ж.Батзолбоо	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад;
	4. Б.Пүрэвдорж	Бууцагаан сум дахь Гал түймэр унтраах, аврах 72 дугаар ангийн захирагч, ахмад;
	5. Д.Энхбаяр	Онцгой байдлын газрын Эмч-сэтгэл зүйч, дэслэгч;
	6. Ж.Өлзийжаргал	Мал эмнэлгийн газрын Зооноз халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн;
	7. Н.Наранхатан	Зоонозын өвчин судлалын төвийн Нян судлагч эмч;
Нарийн бичиг	8. Э.Лувсанпэрэнлэй	Гал унтраах автомашины жолооч, ахлагч;
	9. Г.Баярсайхан	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч.

.....оОо.....

Аймгийн Засаг даргын *М.С.* оны *10* дугаар сарын *11*-ний өдрийн *1/11* дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГУУЛЬ ДАДЛАГА,
БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХУВААРЬ**

Д/д	Сургууль дадлага, бэлэн байдлын үзлэг зохион байгуулагдах сум	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	2	3	4	5
Гамшгаас хамгаалах "Иж бүрэн сургууль"				
1.	Баянбулаг	2023.09 сар	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв
Гамшгаас хамгаалах "Команд штаб"-ын сургууль				
2.	Бөмбөгөр	2023.09 сар	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв
Аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах "Бэлэн байдлын үзлэг"				
3.	Гурванбулаг	2023.09 сар	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв

.....оОо.....

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 17 ний өдрийн 154 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГУУЛЬ ДАДЛАГАД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

А. ШАТАХУУН

Д/д	Сумын нэр	Зохион байгуулах хугацаа	Автомашин	Нийт явах зам (км)	Сул явалт (км)	Шатахууны норм (дизель)	Зарцуулах шатахуун (литр)	Шатахууны үнэ /төгрөг/	Нийт
1	2	3	4	5	6	7	8	9	10
1.	Бөмбөгөр	2023.10.20- 2023.10.31	Ланд Крузер	100	50	20	40	3840	153,600
2.	Баянбулаг			176	50	20	60	3840	230,400
3.	Гурванбулаг			80	50	20	40	3840	153,600
4.	Нийт			356	150	20	140	3840	537,600

Б. СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН МАТЕРИАЛ

Д/д	Нэр		Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд	
1	2		3	4	5	
1.	Гал унтраагуур		9	80,000	720,000	
2.	Урьдчилан сэргийлэх ажлын зардал	Принтерийн хор (өнгөт)	Гарын авлага, санамж, зөвлөмж материал хэвлэх	6	96,000	576,000
3.		Бичгийн цаас		6	20,000	120,000
4.		Фото цаас (инктэй)		6	55,000	330,000
5.	Нийт				1,746,000	

В. НЭГДСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Нэр	Нийт зардал
-----	-----	-------------

1	2	3
1.	Шатахуун	537,600
2.	Сургалтын хэрэглэгдэхүүн, урьдчилан сэргийлэх ажлын материал	1,746,000
3.	Нийт дүн	2,283,600

.....oOo.....